

Дархан уул аймгийн Шарын гол  
сумын Монгол Ардын намын хорооны  
гишүүдийн 2020 оны 06 сарын 21 өдрийн  
10 дугаар тогтоолын хавсралт

**АЙМАГ, СУМЫН ИТХ-ЫН 2020 ОНЫ ЭЭЛЖИТ СОНГУУЛЬД ОРОЛЦОХООР  
ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ШАРЫН ГОЛ СУМЫН МОНГОЛ АРДЫН НАМААС ДЭВШҮҮСЭН  
“ТОГТВОРТОЙ БОДЛОГО-ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ” МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

Шарын гол

**УРИА: “СУМЫНХАА ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨ ХҮЧЭЭ НЭГТГЭЭ”**

**ЗОРИЛГО**

Сумын нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх ойрын жилүүдийн бодлогыг тодорхойлон, түүнийг хэрэгжүүлэхэд үйл ажиллагааны зорилго оршино.

**АГУУЛГА**

НЭГ. Хүний хөгжил, Нийгмийн бодлого:

ХОЁР. Ногоон хөгжил, Байгаль орчныг хамгаалах бодлого:

ГУРАВ. Санхүү, эдийн засгийн бодлого:

ДӨРӨВ. Эрх зүй, төрийн байгуулалтын бодлого:

ТАВ. Тохилог орчныг бүрдүүлэх, хот байгуулалт, тохижилтын бодлого

ЗУРГАА: Орон нутгийн хөгжлийн бодлого:

**НЭГ. ХҮНИЙ ХӨГЖИЛ, НИЙГМИЙН БОДЛОГО:**

Хүний эрхийг хангах, хүүхэд залуучууд бүх талаар сурч боловсрох, иргэд ажил хөдөлмөр эрхэлж өрхийн орлогоо нэмэгдүүлэх боломж нөхцөл бүрдүүлж, нийгмийн бүлэг бүрт үзүүлэх үйлчилгээг оновчтой болгоход чиглэгдэнэ.

1.1 Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын үйл ажиллагааг өргөжүүлэх ажлыг бодлогоор дэмжинэ.

а. Гэр хороололд цэцэрлэг шинээр байгуулж хамрагдалтыг нэмэгдүүлнэ.

б. Хүүхэд харах үйлчилгээг дэмжиж өргөжүүлнэ.

в. Зарим цэцэрлэгт 1-2 хуртэлх насны хүүхдийг хамруулж яслийн анги, бүлэг ажиллуулна.

*Үр дүн: Эрүүл Монгол хүүхдийг төлөөшүүлэх суурь нөхцөлийг хангана.*

1.2 Боловсролын салбарын сургалтын чанарыг сайжруулж, материаллаг бааз хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, үйл ажиллагааг бодлогоор дэмжинэ.

а. Багш нарын хангалтыг нэмэгдүүлж, нийгмийн асуудлыг шийдвэрлэх, “Чадварлаг багш” хөтөлбөр хэрэгжүүлнэ.

б. Сургалтын менежментийг сайжруулах замаар түүх хэл соёл, үндэсний өв уламжлал, зан заншил, үнэт зүйлсээ дээдэлсэн агуултыг бүхий хөтөлбөр хэрэгжүүлж, эх оронч чадварлаг зөв монгол хүүхдийг төлөвшүүлнэ.

в. Сумын сургуулиудыг цогцолбор сургууль болгох асуудлыг дэмжиж ажиллана.

е. Сургуулиудад өдөр өнжүүлэх анги бүлэг хичээллүүлэхийг бодлогоор дэмжинэ.

ё. Бүх нийтийн боловсрол олгох зайны сургалтыг дэмжиж ажиллана.

*Үр дүн: Боловсролын түвшин Улсын дунджаас дээшилж аймагтаа тэргүүлнэ.*

1.3 Эрүүл мэндийн төвийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, “Элэг бүтэн монгол, “Эрүүл шүд- Эрүүл хүүхэд”, “Эрүүл чийрэг эр хүн”, “Энх бүсгүй” хөтөлбөрүүдийг хэрэгжүүлнэ.

а. Мэргэжлийн боловсон хүчнийг бодлогоор бэлтгэж нэмэгдүүлэх, нийгмийн асуудалд анхаарч ажиллана.

б. Гэр хороолол дахь багийн байрыг түшиглэн иргэдэд эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг зохион байгуулах боломж бүрдүүлнэ.

в. Хөнгөлөлттэй эмийн олголт, эм ханганд нийлүүлэлтийг бодлогоор нэмэгдүүлнэ.

г. Эрүүл мэндийн төвийн дэргэд иргэд, ахмад болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд зориулсан эмийн бус уламжлалт эмчилгээ, нөхөн сэргээх өдрийн үйлчилгээг нэвтрүүлж эрүүл амьдралын дадал хэвшлийг төлөвшүүлэхэд анхаарна.

д. Сумын Эрүүл мэндийн төвийг хэрэгцээний халуун усаар хангана.

*Үр дүн: Эрүүл мэндийн төвийн бүтэц зохион байгуулалтыг улсын стандартад нийцүүлж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна.*

1.4. Нийтийн биеийн тамир, спортыг хөгжүүлж үйл ажиллагааг дэмжинэ.

- а. Спорт ордны бүтэц, зохион байгуулалт, санхүүгийн бие даасан байдлыг хангаж, материаллаг баазыг бэхжүүлж үйл ажиллагааг өргөжүүлнэ.
- б. Спортын сонгодог төрлүүдийг хөгжүүлэх бодлого баримталж, үндэсний спортыг дэмжинэ.
- в. Хөл бөмбөгийн талбайг засварлан тохижуулж спортын цогцолбор байгууламжийг бий болгоно.
- г. Сургуулиудын гаднах спортын талбайг орчин үеийн стандартад нийцүүлэн шинэчилж сайжруулна.
- д. Спорт ордны их засварын ажлыг хийж гүйцэтгэнэ.

*Үр дүн: Спортын бааз, суурь бүрдүүлж бүх нийтийн биеийн тамирыг хөгжүүлнэ.*

1.5 Хотын соёлыг төлөвшүүлэх, соёл урлагийг дэлгэрүүлж, соёлын өвийг хадгалан хамгаалах, судлах, сурталчилах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

- а. Соёлын төвийн дэргэд студи, цахим номын сан, мини кино театр, сум сурталчилах танхим (музей) байгуулах замаар соёл, урлагийн үйл ажиллагааг өргөжүүлнэ.
- б. Түүх, соёлын үнэт зүйлс биет болон биет бус өвийн хадгалалт хамгаалалтыг сайжруулж, соёлын төвийн дэргэдэх төрөл бүрийн дугуйланг ажлуулахыг бодлогоор дэмжинэ.
- в. Иргэдийг соён гэгээрүүлж, соёлтой харилцааг хэвшүүлэн, хотын соёлыг төлөвшүүлнэ.
- г. Соёлын төвийн барилгын их засварын ажлыг хийж гүйцэтгэнэ.

*Үр дүн: Соёл, урлагийг дээдлэх, соёлтай харилцааг эрхэмлэх дадал, хандлага төлөвшинэ.*

1.6. Иргэдийн хөдөлмөр эрхлэлт, ажлын байрыг нэмэгдүүлэх, мэргэжилтэй ажилчин бэлтгэх давтан сургах үйлчилгээг бодлогоор дэмжинэ.

а. Төр болон хувийн хэвшлийн томоохон ААНБ-тай хамтран судалгаанд тулгуурлан байнгын болон түр ажлын байрыг нэмэгдүүлнэ.

б. Бизнес эрхлэгчдийг дэмжинэ.

в. Гарааны бизнес, өрхийн бичил үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлэхэд СХС, ЖДҮСангийн хөнгөлттэй зээлд хамруулах ажлыг өргөжүүлнэ.

г. Иргэдийг мэргэжил эзэмшүүлэх ур чадварыг ахиулах сургалтад хамруулж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ.

д. Шинээр хашаа байшин, орон сууц барьж буй иргэдийг ипотекийн зээлд хамруулна.

*Үр дүн: Өрхийн орлого нэмэгдэж иргэдийн амьдарлын чанар дээшлэнэ.*

1.7 Сумын онцлогт тохирсон мал аж ахуйг хөгжүүлж, хагас эрчимжсэн МАА-д шилжих суурь нөхцөлийг бүрдүүлнэ.

а. Аймгийн малын удмын сангийн төвтэй хамтран өндөр ашиг шимт мал аж ахуйг хөгжүүлж, нэгж малаас авах ашиг шим, цэвэр үүлдрийн хээлтэгч, хээлтүүлэгчийг нэмэгдүүлж, үхэр, хонин сүргийг голлох бүтэц болгоход анхаарч “Монгол мал-2” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

б. Зэргэлдээ сумдуудтай хамтран ажиллах санамж бичгийг баталгаажуулах замаар бэлчээр, өвөлжөөний газар эзэмших асуудлыг шийдвэрлэх, хадлангийн талбайг гэрээнд тулгуурлан олгох, хэрэглээний мод олгуулах ажлыг үргэлжлүүлж, бэлчээрийн зүй зохистой менежмент хэрэгжүүлнэ.

в. Малчин буюу мал бүхий иргэд шилжин ирэх асуудалд онцгой анхаарч, малын тоо толгойг одоо байгаа түвшинд барих, эдийн засгийн эргэлтэнд оруулах асуудлыг дэмжинэ.

г. Уул уурхайн үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудтай хамтран бэлчээрийн талбайг нэмэгдүүлнэ.

д. Малын эрүүл мэндийг хамгаалах зорилгоор зөөврийн мал угаалгын төхөөрөмжтэй болно.

е. “Малчдын дундын сан” бий болгож бэлчээрийг нөхөн сэргээх ажлыг бодлогоор дэмжинэ.

*Үр дүн: Бэлчээрийн чанар сайжирч цэвэр үүлдрийн өндөр ашиг шимт МАА хөгжинө.*

1.8 Хөдөө аж ахуйг дэмжих, эрүүл хүнсээр хангах бодлогыг баримтална.

а. Гахай, шувуу, зөгийн байран маллагаатай эрчимжсэн аж ахуйг дэмжиж, экологийн цэвэр бүтээгдэхүүнээр иргэдээ хангах асуудлыг бодлогоор дэмжинэ.

б. Жимс жимсгэнэ, төмс, хүнсний ногоо тариалах, өрхийн аж ахуйг хөгжүүлэх, сайн сортын үрээр хангах, эх орны хөрсөнд ургасан хүнсний бүтээгдэхүүнээр иргэдийг хангах боломжийг бүрдүүлж өвлийн хүлэмж барих иргэдийг дэмжиж ажиллана.

в. Мах, махан бүтээгдэхүүн хадгалах зоорь барих ажлыг бодлогоор дэмжинэ.

Үр дүн: Эрүүл, аюулгүй хүнсээр хангах боломж бүрдэнэ.

1.9 Нутгийн захиргааны байгууллага гадаадын орнуудтай найрсаг, хамтын ажиллагааг хөгжүүлэх ажлыг өргөжүүлнэ.

## ХОЁР. НОГООН ХӨГЖИЛ, БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ БОДЛОГО:

Хүрээлэн буй орчны экологийн тэнцвэрт байдлыг хадгалах байгаль орчинд зэлтэй орчныг бүрэлдүүлэхэд чиглэгдэнэ.

2.1. Уул уурхайн үйлдвэрлэлийн улмаас эvdэрч доройтсон эзэнгүй орхигдсон талбайд төсөл, хөтөлбөрөөр нөхөн сэргээлт хийх, эзэн холбогдогчийг тогтоолгон хохирол нэхэмжлэх ажлыг зохион байгуулна.

2.2. “Дулаан Шарын гол” ТӨХК , “Шарын гол” ХК-н үйлдвэрийн талбайн болон хаягдал бохир усны асуудлыг шийдвэрлэж Шарын гол орчмын бохирдлыг бууруулна.

2.3. Бичил уурхайгаар үйл ажиллагаа явуулж буй иргэдийн асуудлыг хуулийн хүрээнд бодлогоор дэмжиж нөхөн сэргээсэн талбайд уул уурхайн олборлох үйл ажиллагаа явуулахыг хязгаарлана.

2.4. Үнд ахуйн цэвэр усны эх үүсвэр нөөц газар, Шарын гол, Буянт, Хавчуу, Шаазгайтын голын гольдролыг хамгаалах, бохирдоос сэргийлэх ажлыг дэмжинэ.

2.5. Тоосжилт, агаар, хөрсний бохирдоос сэргийлэх, эvdрэл элэгдлээс хамгаалах, орчны эрүүл ахуйн нөхцөлийг хангах ажлуудыг дэс дараатай хэрэгжүүлнэ.

2.6. Ойн санг гэрээгээр эзэмшигч нөхөрлөлүүдтэй хамтран ажиллаж, хууль бус мод бэлтгэлтэй тэмцэнэ.

Үр дүн: Иргэдийн экологийн боловсрол дээшилж, ногоон хот хөтөлбөр хэрэгжинэ.



## ГУРАВ. САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО:

Эдийн засгийн хүрээнд баримтлах бодлого нь төсөв, санхүү, татварын бодлогыг оновчтой тодорхойлж, сумын санхүү, эдийн засгийн чадавхийг нэмэгдүүлэх, хувийн хэвшлийг дэмжин хөгжүүлэхэд чиглэгдэнэ.

3.1 Олон Улсын болон бусад төсөл хөтөлбөрт хамрагдан хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.

3.2 Төсвийн хариуцлага хяналтыг сайжруулж, ил тод байдлыг хангаж ажиллана.

3.3 Сумын эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэх бүх талын боломжийг судлан хэрэгжүүлнэ.

3.4 Төрийн болон орон нутгийн өмчийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтыг сайжруулахад чиглэсэн бодлого баримтална.

3.5 Статистик мэдээ, мэдээллийн үнэн зөв, ил тод бие даасан зарчмыг хангуулан ажиллана.

3.6 Бизнесийн таатай орчинг бүрдүүлж, орон нутгийн хэрэгцээг өөрөө хангах бодлого баримтална.

Үр дүн: Ажлын байрыг нэмэгдүүлэх замаар сумын эдийн засгийн өсөлтийг хангаж, орон нутгийн төсвийн тогтвортой, бие даасан байдал, санхүүгийн чадавхи бэхжинэ.

## ДӨРӨВ. ЭРХ ЗҮЙ, ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БОДЛОГО:

Төрийн үйлчилгээний ил тод, нээлттэй шударга, шуурхай байдлыг хангуулж төрийн үйлчилгээний чанарыг сайжруулахад чиглэгдэнэ.

4.1 Бүх шатны төрийн албан хаагчдийг чадавхижуулах, ёс зүйн хэм хэмжээг төлөвшүүлэх, мэргэжлийн боловсон хүчны хангалтыг нэмэгдүүлэх, нийгмийн асуудлыг шийдвэрлэнэ

4.2 Төрийн байгууллагуудын ажил үүргийн давхардал, хийдлийг арилгаж, зохион байгууллалтыг оновчтой болгож төрийн үйлчилгээг шуурхай хүргэнэ.

4.3 Хариуцлагын тогтолцоог хэрэгжүүлэх, хяналтыг сайжруулна.

4.4 Орон нутгийн мэдээллийн хэрэгсэл, цахим орчин ашиглан төрийн үйлчилгээний талаарх мэдээллийг иргэдэд хүргэх, орон нутгийн хөгжлийн асуудлаар аливаа бодлогын баримт бичгийг гаргахдаа улс, аймгийн хөгжлийн урт хугацааны үзэл баримтлалд тулгуурлан боловсруулж, төслийг иргэдээрээ урьдчилан хэлэлцүүлж, гарсан санал дээрээ үндэслэн шийдвэр гаргаж хэвшүүлнэ.

4.5 Иргэдийн амгалан тайван ажиллах, амьдрах нөхцлийн бүрдүүлж, ГХУСэргийлэх, цагдаа, иргэний нийгмийн байгууллага болон иргэдийн оролцоо, хамтын ажиллагааг идэвхижүүлнэ.

4.6 Төрийн болон төрийн бус байгууллага, ААНБ-тай үр дүнгийн эсхүл хамтран ажиллах гэрээ байгуулах замаар нийгмийн салбар хоорондын хамтын ажиллагааг нэгтгэж, хамтын оролцоог нэмэгдүүлнэ.

4.7. Сумын хэмжээнд байгалийн гамшгаас хамгаалах, урьдчилан сэргийлэх, хор хөнөөлийг арилгах, нөхөн сэргээх чадавхийг нэмэгдүүлнэ.

4.8 Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын ажил үйлчилгээг чанаржуулах, боловсон хүчнийг мэргэшүүлэх, ажиллах нөхцлийг сайжруулах, бодлого баримтлана.

4.9 Амралт, аялал жуулчлалыг хөгжүүлэхэд чиглэгдсэн хөтөлбөр боловсруулан гарана.

*Үр дүн: Төрийн үйлчилгээ тогтвортой, чадварлаг, нийтэд хүртээмжтэй, шинжлэх ухаанд суурилсан мэргэжлийн үр чадвартай, нийтлэг харилцааг эрхэмлэсэн байна.*

**ТАВ. ТОХИЛОГ ОРЧНЫГ БҮРДҮҮЛЭХ, ХОТ БАЙГУУЛАЛТ,  
ТОХИЖИЛТЫН БОДЛОГО:**

Шарын гол сумын 2030 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу хот төлөвлөлт, газар зохион байгуулалтын ажлыг хийж, гүйцэтгэлийн хяналтыг нэмэгдүүлнэ.

5.1 Гэр хорооллын айл өрхүүдийг утаагүй зуух, бүрэн шаталттай түлшээр хангах ажлыг үргэлжлүүлнэ.

5.2 Шарын гол сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан газар зохион байгуулалтын төлөвлөгөө, хэсэгчилэн төлөвлөгөөнүүдийг баталж хэрэгжүүлнэ.

5.3 Хот тохижилтүн хэсгийн менежментийг шинэчилж сумын төвлөрсөн хогийн цэгийн асуудлыг шийдвэрлэнэ.

5.4 Хуулийн хүрээнд иргэнд 1 удаа үнэгүй газар өмчлүүлэх асуудлыг хөрш зэргэлдээ сумдуудтай хамтран шийдвэрлэх бодлого баримтлана.

5.5 Гэр хорооллын иргэдийн усан хангамжийг нэмэгдүүлж төвлөрсөн системд хэсэгчлэн холбох ажлыг үргэлжлүүлнэ.

5.6 Нийтийн эзэмшлийн гудамж, талбай, гэрэлтүүлэг, авто болон явган замыг засварлаж, хүүхдийн тоглоомын болон биеийн тамирын мини талбай, ногоон байгууламжийг нэмэгдүүлэн тохижилтүг сайжруулж үерийн далан, суваг засварлах ажлуудыг үе шаттай хийж гүйцэтгэнэ.

5.7 “Шинэ орчин” хорооллын инженерийн шугам сүлжээ, зам, гэрэлтүүлэг, барилгын ажлыг үргэлжлүүлнэ.

5.8. “Тохилог гэр хороолол” төсөл хэрэгжүүлнэ.

5.9 Орон сууцны гадна фасад, дээвэр засварын ажлуудыг үргэлжлүүлнэ.

5.10 Дулаан хуваариалах төвөөс 11-р таван давхар байр хүртэлх дулаан түгээх төв шугамын өргөтгөл ажлыг хийнэ.

*Үр дүн: Иргэдийн амьдрах тохилог орчныг бүрдүүлнэ.*

## ЗУРГАА. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО:

Орон нутагт бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалт ажлыг байрыг нэмэгдүүлэнэ.

- 6.1. Дархан хотыг цаашид Эрдэнэт, Сэлэнгийн бүс нутгийг сайжруулсан шахмал түлшээр хангах үйлдвэрийг байгуулах төслийг Шарын гол суманд хэрэгжүүлэх бодлого барьж ажиллана.
- 6.2. “Дулаан Шарын гол” ТӨХК-ийн дулааны станцын өргөтгөл, цэвэрлэх байгууламжийн шинэчлэлийг эхлүүлнэ.
- 6.3. Дархан-Шарын голыг холбосон хатуу хучилттай авто замын барилгын ажлыг үргэлжлүүлэн дуусгана.
- 6.4. Улаанбаатар-Шарын гол чиглэлийн авто замын зураг төсөв боловсруулах ажлыг хийнэ.
- 6.5. Сумын онцлогт тохирсон Мини усан бассейн байгуулах ажлыг эхлүүлнэ.
- 6.6. Хүүхэд, залуучуудын хөгжлийн төв байгуулна.
- 6.7. “Найрамдал” талбай, “Мини цогцолбор”-ын шинэчлэлийн ажлыг хийж дуусгана.
- 6.8. Ашиглалтын хугацаа дууссан 2 давхар байруудыг дахин төлөвлөлтөнд хамруулна.
- 6.9. Сумын төвийн I, II дугаар салбар зам, гүүрийн барилгын ажлыг хийж дуусгана.
- 6.10. Бууртын хөндийн унд ахуйн цэвэр усны шинэ эх үүсвэрийн газар нутгийг аймгийн тусгай хамгаалалтанд авч бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлнэ.
- 6.11. Аялал жуулчлалыг хөгжүүлэх бүтээн байгуулалтын ажлуудыг дэс дараалалтай эхлүүлнэ.
- 6.12. Ахмадын спортын “Мини заал” барьж ахмадын хөгжлийн төвтэй болно.
- 6.13. Шарын гол сумыг 2050 он хүртэл хөгжүүлэх “Мастер төлөвлөгөөг” боловсруулж батлана.

Аймаг нийслэл сум дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль, “Хөгжлийн гэрээ хөтөлбөр”, Аймгийн МАН хорооны мөрийн хөтөлбөр, Сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө зэргийг харгалзсан болно.

Нийт 6 бүлэг, 41 заалт 51 тусгай зүйл бүхий.

**Ажлын хэсэг**

## 2. БАГИЙН ХӨГЖИЛ:

### 1. Хайрхан баг

- а. Сумын төвийн доторхи хатуу хучилттай замын засвар, арчлалтын ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ.
- б. Соёлын төвийн барилгын гадна фасад, дотор засварын ажлыг хийнэ.
- в. Спортын ордны барилгын их засвар хийнэ.
- г. "Найрамдал" талбайн засварлаж шинэчилж тохижуулна.
- д. Хүүхэд, залуучуудын хөгжлийн төв шинээр байгуулна.
- е."Хөл бөмбөг"-ийн талбайг шинэчлэн засварлаж, тохижуулна.
- ё. Сумын төвийн үерийн даланг засварлаж шаардлагатай хэсэгт шинээр хийнэ.
- ж. 2 давхар байруудын дээвэр засварын ажлыг эхлүүлж, үе шаттай хэрэгжүүлнэ.
- з. Ахмадын спортын "Мини заал" шинээр барьж "Ахмад хөгжлийн төв" болгоно.
- и. Хүүхэд залуучуудын "Мини" цогцолбор, цэцэрлэгт хүрээлэнг засварлаж, тохижуулна.
- й. Дулаан хуваарилах төвөөс 11-р таван давхар байр хүртэлх дулаан түгээх төв шугамын өргөтгөл ажлыг хийнэ.
- л. Цэвэрлэх байгууламжийн засвар шинэчлэлийг хийнэ.
- м. Ашиглалтын хугацаа дууссан 2 давхар байруудыг дахин төлөвлөлтөнд хамруулна.

### 1. Дархан баг

- а. Тосгоны хэсгээс Хоккейчид хүртэлх хатуу хучилттай бетон замыг барьж дуусгана.
- б. Гудамж, зам талбайн зарим хэсэгт эко гэрэлтүүлэг шинээр тавина.
- в. Жишиг гудамж байгуулна.
- г. Хүүхдийн тоглоомын болон Биеийн тамирын талбай байгуулна.
- д. Сумын төвөөс "Их бодь суварга" хүртэл явган хүний алхалтын зам тавина.
- е. "Шинэ орчин" амины орон сууцны хороолол үргэлжлүүлнэ.

### 3. Санжинт баг:

- а. Гудамж, зам талбайн шаардлагатай зарим хэсэгт эко гэрэлтүүлэг шинээр тавина.
- б. Зарим гудамжны зам талбайг хусч тэгшлэн хайргажуулж засварлана.
- в. Тохилог гэр хороолол" төсөл хэрэгжүүлж инженерийн шугам сүлжээг холбох ажлыг эхлүүлнэ.
- г. Хөдөөгийн малчдад зориулж шаардлагатай хэсэгт ундны болон бэлчээрийн худаг шинээр гаргаж усан хангамжийн асуудлыг шийдвэрлэнэ
- д. Зөөврийн мал угаалгын төхөөрөмжтэй болно.
- е.Хүүхдийн тоглоомын болон Биеийн тамирын талбай байгуулна.